



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

**Байгууллагын 2023-2024 оны стратеги  
төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн  
бүрэлдэхүүн батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, Засгийн газрын 216 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/667 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг үндэслэн Өмчийн харилцааны газрын 2023-2024 оны стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралт ёсоор байгуулсугай.

2. Байгууллагын 2023-2024 оны стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Байгууллагын стратеги төлөвлөгөөний төслийг 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн дотор боловсруулан, байгууллагын Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч (Ц.Цэрэндулам)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.САЙХАНБАЯР

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын  
2023 оны .03.. дугаар сарын ..15.. өдрийн  
А/18... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Цэрэндулам	Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтсийн дарга
Гишүүд:	М.Мөнхбаяр	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга
	М.Энхболд	Өмчийн менежментийн хэлтсийн дарга
	Н.Хашцэцэг	Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтсийн дарга
	С.Учрал	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Хуулийн мэргэжилтэн
	Н.Болормаа	Өмчийн менежментийн хэлтсийн мэргэжилтэн
	Я.Одгэрэл	Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтсийн мэргэжилтэн
Ажлын хэсгийн нарийн бичиг:	Ц.Цолмон	Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн
	П.Түвшинжаргал	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын  
2023 оны 03 дугаар сарын 15 өдрийн  
А/18 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



БАЙГУУЛЛАГЫН 2023-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ  
АЖЛЫН ХЭСГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 оны 03 дугаар сарын 14

Улаанбаатар хот

№	Стратеги төлөвлөгөөний бүтэц, агуулга	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэх ажил	Хариуцах албан хаагчид	Хугацаа
1	2	3	4	5	6
1	Нийтлэг үндэслэл	-Ямар бодлогын баримт бичигт үндэслэж байгаа -Яагаад стратеги төлөвлөгөө боловсруулж байгаа -Ямар шаардлага, үндэслэл үүссэн зэргийг асуултад хариулахуйц 1-2 хуудсанд багтаасан	Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө, байгууллагын 2017-2020 оны стратеги төлөвлөгөөнүүдийг удиртгал болгон ажиллана	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн	2023.03.14- 2023.03.21
2	Мандатын шинжилгээ	Газрын үйл ажиллагаанд хамаарах чиг үүргийг тодорхойлсон байх	Салбарын хүрээнд мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжуудыг тодорхойлон, ерөнхий болон дэд чиг үүргүүдийг хүснэгтийн дугаа жагсаана	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн	2023.03.14- 2023.03.21
		Холбогдогч талуудыг тодорхойлсон байх	Холбогдогч талуудыг дээшээ чиглэл, доошоо чиглэл, хэвтээ чиглэлээр ангилан схем зураг гаргана Талуудын оролцоог харуулсан хүснэгт гаргана	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн	2023.03.14- 2023.03.21
		Чиг үүргийн хэрэгжилтийг тодорхойлсон байх	Ерөнхий болон дэд чиг үүргүүдийн дагуу хэрэгжилт, хувийг тодорхойлсон хүснэгтийг боловсруулна	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн	2023.03.14- 2023.03.21

3		НЗД-д олгосон захиргааны эрх хэмжээний хүрээнд газрын даргад олгосон захиргааны хэм хэмжээг тодорхойлсон байх	Ерөнхий болон дэд чиг үүргүүдийн захиргааны хэм хэмжээний ангилалаар тодорхойлсон хүснэгтийг боловсруулна	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн	2023.03.14-2023.03.21
4	Алсын хараа, Эрхэм зорилго, Уриа үг, Үнэт зүйл	Байгууллагын ирээдүйд хүрэх үр дүн, оршихуйн илэрхийллийг агуулсан байх	Газрын дүрэмд тусгасан эрхэм зорилгыг үндэслэсэн алсын хараа, уриа үг, үнэт зүйлсийг шинэчлэн боловсруулна	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн	2023.03.14-2023.03.21
5	Орчны шинжилгээ	SWOT шинжилгээний аргад суурилан орчны шинжилгээг хийх	Байгууллагын гадаад болон дотоод орчны шинжилгээ, үүнээс үүдсэн эрсдэл, давуу, сул тал болон боломжийг хүснэгтэн хэлбэрээр тодорхойлно		2023.03.14-2023.03.21
6	Стратегийн зорилго	Стратегийн зорилго тодорхойлох	Стратегийн зорилгыг нийслэлээс өгсөн заавар, хүснэгтийн дагуу тодорхойлно	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн	2023.03.14-2023.03.21
7	Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги	Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратегийг тодохойлох	Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратегийг боловсруулна	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн	2023.03.14-2023.03.21
8	Стратегийн зорилго ба салбар, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын бүтэцийн уялдаа, зураглал	Стратегийн зорилго ба салбар, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын бүтэцийн уялдаа, зураглалыг тодорхойлох	Стратегийн зорилго ба салбар, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын бүтэцийн уялдаа, зураглалыг хүснэгтэн хэлбэрээр боловсруулна	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн	2023.03.14-2023.03.21
9	Хавсралт (Стратеги төлөвлөлтийн хүрээнд хийсэн ажлын тайлан бусад материал)	Хавсралтуудыг нэгтгэх	Хавсралтуудыг жагсаана	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн	2023.03.14-2023.03.21